



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Бүртгэл, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар тус тус батлахыг "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхыг "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвлөсүгэй.

4.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба (В.Жавзан)-д даалгасугай.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн "Зөвшөөрөл олгох тухай" 2020 оны 128 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН

1525011031



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Үйлдвэр, тээвэр, логистикийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хамтын ажиллагааны бүс хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Цахим аюулгүй байдал, сервер хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Цахим систем, хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн Худалдан авалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Ногоон хөгжил, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Бүртгэл, санхүүгийн хэлтсийн Мэдээлэл, үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар хавсралтаар тус тус батлахыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д даалгасугай.

1525011035

3.Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвлөсүгэй.

4.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба (В.Жавзан)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН



## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 372

Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Захирагчийн туслахын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн Олон улсын эдийн засагчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн Хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Гэрээ, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Бүртгэлийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Хот төлөвлөлт, газар зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Инженерийн хангамж, дэд бүтэц хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар хавсралтаар тус тус батлахыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхыг “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагч (Д.Дамдинцэрэн)-д зөвлөсүгэй.

1525011045

4.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба (В.Жавзан)-д даалгасугай.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн "Зөвшөөрөл олгох тухай" 2020 оны 125 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН





